

ТОТЕМ ШҮТЛЭГ БА ХОРИО ЦЭЭРИЙН ТУХАЙ З.ФРЕЙДИЙН ПСИХОАНАЛИТИК БАРИМТЛАЛ

Р.Дарьхүү (Ph.D)

С.Хишигтогтох (Докторант)

Философи, шашин судлалын тэнхим

ШУС. МУИС

Түлхүүр үг: Айдас, хүсэл, хорио цээр, тотем шүтлэг, сүнс, итгэл үнэмшил, ёслол үйл, хүрэлцэл үйл, зан заншил.

Товч утга: Энэ өгүүлэлд хүсэл, айдас, итгэл үнэмшил, ёслол үйл, зан заншил зэрэг ойлголтын агуулгаар дамжуулан З.Фрейд психоаналитик онолынхоо үүднээс тотем шүтлэг, хорио цээрийг уг гарлыг хэрхэн судалсан, бас соёлын энэ хоёр бүрдэл Монголын соёлын амьдралд хэрхэн холбогддог тухай шинжлэн үзнэ. З.Фрейд угсаатны зүйн олон бүтээл дээр тулгуурлан хүн төрөлхтөний түүхэнд тотем шүтлэг хэрхэн бий болсон, эл шүтлэгийн уг гарлыг психоаналитик онолын үүднээс хэрхэн үндэслэж болох тухай онолын баримтлалаа боловсруулжээ. Тотем шүтлэгийн уг гарлыг психоаналитик онол, арга зүйн хэмжүүрээр атейст байр сууринаас тайлбарласан нь хорио цээр үүсэх сэтгэл зүй, нийгмийн хүчин зүйлийг мөн авч үзэх үндэслэл болсон байна.

* * * * *

“Онгон шүтлэг ба хорио цээр (1913)”, “Нэгэн хуурмаг үзэгдлийн хэтийн төлөв (1927)”, “Моисей ба монотеизм (1938)”, “Соёлд сэтгэл дундуур хандах нь (1930)” зэрэг бүтээл нь шашныг авч үзсэн З.Фрейдийн гол бүтээлүүд юм. “Онгон шүтлэг ба хорио цээр” бүтээлдээ тэрээр хүн төрөлхтөн тотемыг шүтэх болсон сэтгэл зүйн хэрэгцээ шаардлага, түүний уг гарлын тухай үзэл баримтлалаа эртний үеийн хөгжлийн түвшинд үлдэж хоцорсон зарим ард түмний нийгмийн байгуулал, хорио цээрийн мөн чанарт тулгуурлан боловсруулжээ. “...хорио цээрийн асуудалд психоанализийн байр сууринаас, өөрөөр хэлбэл, хувь хүний сэтгэцийн үзэгдлийн ухамсаргүй хэсгийн судалгаанд тулгуурлан хандаж буй хэн боловч эдгээр содон үзэгдэл түүнд өөрөөс нь харь хол зүйл биш гэдэгт итгэх болно”¹ гэж эртний «табу» үүрэг хэлбэрээ өөрчилсөн хэдий ч орчин цагийн соёлд үйлчилсээр байна гэсэн санааг З.Фрейд илэрхийлсэн байна. Аливаа хорио цээр ард түмний сүсэг бишрэл дээр үндэслэгдэж, тэдний зан заншил болон дагаж мөрддөг хуулиудын үндэс болж үлдсэн учир хэн бүхэн тодорхой үндэслэл шаардахгүйгээр түүнд захирагдаж байдгийг З.Фрейд өөрийн үзэл судалгаагаараа илрүүлсэн. Энэ үүднээс хорио цээрийг аливаа сүсэг бишрэлийн ойлголтоос салгаж ойлгох боломжгүй гэдгийг түүний үзэл санаа харуулдаг.

Сэтгэцийн эмгэгийг оношлох эмчилгээний арга зүйгээс нийгэм, соёл, шашны судалгаанд З.Фрейд чиглэсэн явдал өвөрмөц учир шалтгаантай, содон судалгаа байсан. З.Фрейдийг нийгэм соёлын уг сурвалж, шүтлэгийн үүсэл рүү хандахад

¹ Фрейд З. (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.23

хүргэсэн асуудал бол зэрлэг ард түмэн ухамсаргүй хүслээ хэрхэн хязгаарлаж, ухамсаргүйн эрсдэлээс тэд өөрсдийгөө яаж хамгаалж байдгийг сонирхох болсон явдал юм. Аливаа зүүд, домог, урлаг болон шашин шүтлэгийн зан үйлд ухамсаргүй шингэсэн байдаг гэж З.Фрейд үздэг. Ийм арга зүйнхээ үүднээс эртний хөгжлийн түвшин дэх ард түмнүүдийн амьдрал дахь шүтлэгийн зан үйлд нь невротой хүмүүс болон бага хүүхдийн инфантель балчир сэтгэл зүйтэй төсөөтэй ухамсаргүй шинж илэрдгийг, тэдгээр ард түмний ухамсаргүй хүслийг хазаарлан баригч хорио цээртэй холбогддог зан үйлийн болон соёлын үндсийг илрүүлэхэд түүний судалгаа чиглэсэн байна. Тотемизмын уг гарлыг З.Фрейд авч үзэхдээ шүтлэгийн үндсэнд байдаг хөнөөгдсөн эцгээ гэсэн гунигийг онцолдог. Тотем бол шүтэн өргөмжлөгдсөн туйлын сайн эцгийн дүр. Эцгийг хөнөөсөн ухамсаргүйн эсрэг наманчлал, гэмшлийн үр дүнд эцгийн дүрийг орлуулсан ариун тотем өргөмжлөгддөг. Ариун тотем бол тэр овгийн шүтээн болж, халдашгүй дархан байхаар өргөмжлөгдсөн. Түүнийг ариун ба амгалан байлгахад зориулсан хатуу чанд хорио цээр үүсжээ гэж З.Фрейд үздэг билээ. Тиймээс тотем шүтлэгт овгуудын хувьд хорио цээрт хамаарагдахгүй зүйл гэж бараг үгүй. Овог бүр өөрсдийн гэх онгон шүтээнийхээ нэрээр нэрлэгддэг тухай З.Фрейд өгүүлдэг. Тэрээр, "... онгон шүтээн нь овгийн элэнц өвөг болох тул овогт хамаарах хүмүүс онгон шүтээнийхээ амийг бүрэлгэхгүй байх ба түүний махыг хэрэглэх, эсвэл түүнтэй холбоотой ямар нэгэн таашаал ханамжийн үйл үйлдэхээс татгалзах ариун үүргээр холбогдсон байдаг. Энэ үүргийг зөрчих нь шууд хорио цээр болдог ба шийтгэлийг агуулдаг"² хэмээн бичжээ.

Эцгийн байр суурьт санаархсан ухамсаргүй дур хүслийн эрхээр эцгийг хөнөөх сэдэл, нөгөө талаас эцгийг хайрлах, түүний сүр хүчийг хүсэмжлэх сэтгэцийн дотоод хоёрдмол хуульд хүн захирагдаж байдаг гэж З.Фрейд үзээд ийм ухамсаргүй төлвийг "эцгийн комплекс" гэдэг ойлголтоор илэрхийлдэг. Энэ үүднээс З.Фрейд эцгийн эрхт ёсны овгийн үед хөнөөгдсөн эцгийн дүрийг өргөмжлөн шүтэх шүтлэг, түүнд холбогдох хатуу хорио цээрээс нийгмийн зохион байгуулалтын бүх хэлбэр, шашин шүтлэгийн зан үйл уг гаралтай гэж тайлбарладаг. Хорио цээр бол аливаа ард түмний оюун санааны амьдралын чухал хэсэг, ертөнцийг үзэхүй нь мөн төдийгүй зарим хэсэг нь ухамсаргүй хэлбэрээр үйлчлэх, зохицуулах үүрэг бүхий хүчин зүйл болж хувирдаг. Иймээс хорио цээрийг судалсан томоохон эрдэмтэд В.Вундт, З.Фрейд нарын дүгнэлтээр "... хорио цээрээс ангид ард түмэн, соёл иргэншил гэж огт байдаггүй"³ Ертөнцийг үзэхүй, шүтлэгийн эртний хэлбэр болох тотемизм хорио цээртэй салшгүй холбоотой үүссэн болохыг З.Фрейд онцлон тэмдэглэж байсан. Түүний үзсэнээр далдын хүчинд итгэх сүсэглэлийн үндсэн дээр цээрлэх ёс үүссэн боловч хожим энэ үндсээсээ салж ард түмэн бүрийн ахуй соёл, газар зүй, сэтгэлгээний онцлогтой уялдан өвөрмөц маягийн зан үйл, улмаар социал хэм хэмжээ, хууль цаазын үндсэн элементийн шинжийг олж, орчин цагийн соёлд ул мөрөө үлдээжээ.

Угсаатны зүйн олон баримтанд тулгуурласан З.Фрейдийн судалгаагаар бол овгийн зохион байгуулалттай ард түмний хувьд "... шашны болон нийгмийн дэг харилцааны оронд австраличуудад онгон шүтэх ёсны тогтолцоо оршин үйлчилж байдаг. Австралийн овгууд нь жижиг гэр бүл, эсвэл отог омгуудад хуваагдаж, тэдгээр тус бүр нь өөрсдийн гэх онгон шүтээнийхээ нэрээр нэрлэгддэг. Энэ байдал ерөнхийдөө бүх өрх бүлд хамаатай, тодорхой харилцаанд байгаа аюултай айдас

² Фрейд З. (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.2

³ Мөн тэнд. х.98

төрүүлэгч амьтан, цөөн тохиолдолд ургамал, эсвэл байгалийн хүч бороо ус гэх мэт юм”⁴ (Фрейд 3.2009. х.2). Гэхдээ шүтээний онгон бол ихэвчлэн амьтнаар орлогдсон нь буй. Хүн төрөлхтний хөгжил, шинжлэх ухааны мэдлэг техникийн ололтууд тотем шүтлэгт нөлөөлсөн ч гэсэн хорио цээрийг тун бага өөрчилжээ гэж З.Фрейд тэмдэглэсэн байдаг. Хэдий тийм боловч тотем нь дэлхийн ард түмний шашин шүтлэгт харилцан адилгүй уламжлагдаж иржээ. Тухайлбал, “... Хүннү, Түрэг, Уйгар, Монгол зэрэг эртний улсуудын талаарх бичгийн болон археологийн дурсгалд чоныг тотемчлон үзэж, өөрсдийгөө түүнээс гарал угсаатай тухай өгүүлсэн мэдээ сэлт цөөнгүй”⁵ болохыг дурдсан байна. Монголчуудын гарлыг шууд чоно, маргал (буга) хоёртой холбон домогчилсон буй тухай судлаачид дурджээ. Монголын нууц товчоонд, Чингис хаан ан авд мордох зарилаг буулгахдаа «*Хоа марал, бөртэ чоно суманд орох буй, түүнийг бүү харва*» хэмээн анхааруулсан мэдээ байдаг.

Монголчуудажбайдлын өвөрмөц онцлогтоо сүсэг бишрэлээ шингээн зохицуулж ирсэнтэй холбогдон хорио цээр нь монгол ахуйн өвөрмөц шинжийг агуулсан гэж болно. Монгол хүн чоныг онгон шүтээнээ болгож байсны бас нэг нотолгоо бидний үеийн соёлд үлдэхдээ нэрийг цээрлэдэг ёсонд шингэжээ. Чонын нэрийг эерүүлэн саарал нохой, гайхал, хэцүү нэрт, тэнгэрийн нохой гэхчлэн харилцан адилгүй цээрлэж нэрлэдэг. Монголчуудын уламжлалт төсөөлөл, ёс заншилд уламжлагдсан амьтны тотемтэй холбогдох зан үйл цөөнгүй. Тухайлбал нялх хүүхдийг амь нас эрсдэхээс хамгаалж амьтантай холбон дом хийх ёс үүний нэг хэлбэр юм.

Хүүхдийг муу юмнаас хамгаалж янз бүрийн онго-зүүлт зүүх явдал түгээмэл байсаар иржээ. С.Бадамхатаны бичсэнээр “... чоныг тотем өвөг дээдсээ болгон үзэх төсөөлөл тогтдоггүй хүүхэдтэй холбоотой нэлээд зан үйлд уламжилж үлдсэн нь огт санамсаргүй зүйл биш бололтой. Тотем өвөг дээдсийн аль нэг зүйл ер бусын хүч чадалтай байдаг мэтээр үзэх, тотем амьтантайгаа цусан төрлийн холбоотой гэсэн ойлголтын ул мөр үндэс байж болох юм. Жишээ нь тогтдоггүй хүүхэдтэй айл хүүхдийн хүйг чонын шөрмөсөөр боож авах, чонын шагай, хоншоорыг хүүхдэд зүүхийг сайн гэж үзэх”⁶ зэрэг нь өнөөг хүртэл монгол угсаатны ёс, бэлгэдэлд тотем шүтлэгийн амьтныг шүтэх итгэл үнэмшил хадгалагддагийн илрэл юм. Ийм итгэл үнэмшил нь “Онгон шүтээн нь омгийн элэнц болохоос гадна ирээдүйг урьдчилан туслагч бөгөөд хамгаалагч сахиусан тэнгэрээ гэж итгэдэг, ер нь онгон шүтээн нь бусдад аюултай байлаа ч өөрийнхөө хүүхдүүдийг таньдаг, өршөөн энэрэгч”⁷ гэсэн итгэл үнэмшилтэй холбогдон эртний өвөг болох тотем шүтлэгийн амьтан удамаа хамгаалах хамгаалалт, өршөөлийг бэлгэддэг утга санаа нь эдүгээ ч хадгалагдаж байдаг.

Тотем шүтлэгийн амьтан бол удам хойчоо өршөөн энэрэгч, хамгаалагч гэсэн далд сүсэг бишрэлийг илэрхийлдэг өвөрмөц бөгөөд монгол хүний итгэл үнэмшил хүчтэй шингэсэн нэг баримт дурдъя. “... монголчууд зарим малдаа дархан эрх олгон түүнийг нядлах, гар хүрэх, цохих, шидэхийг хориглосон тусгай тэмдэг сэтэр зүүж өгдөг. Сэтэртэй малд хэнбугай ч хүндэтгэлтэйгээр ханддаг. ... Малд сэтэр татахдаа сахиус онгодоо залан, сан асаагаад, таван тансаг идээ өргөж, сүү цагаагаа бэлтгэн жил бүрийн билгийн улирлын тавдугаар сарын шинийн есөнд сэтэрлэх малаа авч ирж

⁴ Мөн тэнд. х.2

⁵ Монгол Улсын угсаатны зүй. (2012). Монгол улсын шинжлэх ухааны академи. I боть. Түүхийн хүрээлэн. х.516

⁶ Мөн тэнд. х.517

⁷ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.2

номоо уншин мялааж, тодорхой зан үйл гүйцэтгээд сэтрээ зүүгээд сүрэгт тавьдаг”⁸ Сэтэртэй малд хүндэтгэл үзүүлэх өдрийг “сэтэр эргэх” өдөр гэж нэрлэх нь бий. Сэтэр эргэх өдөр сэтрийг тахиж шүтээгүйгээс гарах үр дагавар нь малд гарз хохирол учирах, өвчин эмгэг тусах зэргээр илэрдэг гэж монгол хүн итгэдэг. Шүтлэгийн эл хэлбэрийн мөн чанар нь эртний тотем шүтлэгийн амьтныг малаар орлуулан сэтэрлэж байгаа нь түүнд овгийн онгоны сүнс, дүрийг шингээж буй утгатай. Авран хамгаалагч, эд баялаг хайрлагч онгон шүтээнийг орлож буй учраас тухайн шүтээний малд хүндэтгэл үзүүлж, түүнээс аврал, энэрэл эсвэл эд баялаг, амар амгаланг хүсэх байдлаар ураг овог, эд мал, ахуй амьдралаа даатган шүтдэг. Энэ нь овгийн онгоныг Монгол хүн өөрийн ахуй амьдралынхаа орчин нөхцөлд нутагшуулж, онгон шүтээний амьтныг малаар орлуулж буй нь психоаналитик онолын ойлголтоор бол «проекции»^{9*}-ийн жишээ юм. Мөн түүнчлэн “...монголчууд хорио цээрийн дэглэмээрээ «табу» гэдэг нэр томъёог дэлхийд түгээсэн полинезчуудээс хэдэн хувь давахаар аман хуулийн тийм нарийн тогтолцоотой ард түмэн юм”¹⁰ гэж Л. Түдэв үзжээ. Монголчуудын цээрлэх ёсны соёл нь тэдний сэтгэлгээнд нэлээд гүнзгий итгэл үнэмшлийг олж, үүний учир монгол хүний харилцаанд оршин буй ёс жаягийг цээрийн ёсгүйгээр төсөөлөх боломжгүй байдаг.

Овгийн хатуу хорио цээрийн нэг бол цус ойртохоос айх айдастай холбоотой хорио цээр байжээ. Энэ тухай З.Фрейд бичихдээ “... онгон шүтлэг байдаг газар орон бүрд бараг нэгэн хууль үйлчилнэ. Энэ нь нэг ижил онгон шүтлэгийн гишүүд өөр хоорондоо бэлгийн харилцаанд орох ёсгүй. ...Энэ нь цаашлаад онгон шүтлэгтэй холбоо бүхий анхны экзогами гэр бүл үүсэх уг сурвалж болсон.Тэдний нийгмийн бүхий л зохион байгуулалт энэ зорилгод чиглэсэн, тийм амжилтад хүрсэн түвшинд байдаг.”¹¹ (З.Фрейд. 2009, х.2) Овог дотор ураг барилдахыг хатуу хориглохоос гадна “... эдгээр ард түмний заримд бүсгүй хүн ба хадам эцгийн энгийн харилцаанд хориг хязгаар байдаг. ...Зарим тохиолдолд хадам эцэг, хадам эх ч зайлсхийх зүйл, учир шалтаг болдог”¹² (З.Фрейд. 2009, х.10) тухай өгүүлсэн нь бий. Эртний ийм хорио цээрийн хэлбэр манай соёлд хүндэтгэлийн утгатай болж, хадам ба бэр, хүргэний хооронд нарийн дэг жаяг, цээрийн ёс байдлаар үлджээ. “... бэр хадам эцгийнд анх орохдоо бурхан шүтээн гал голомтод нь мөргөдөг. Мөргөх ёслол дууссанаар бэр хадмын гэр бүлийн бүрэн эрхт хүн болдог. Энэ ёслол нь эртний үүсэлтэй бөгөөд овгийн байгууллын үеийн төсөөлөл ёсоор харь овгийн хүнийг өөрийн овогтоо элсүүлэн авч буйн учир утгыг илэрхийлж байжээ.”¹³ Эдүгээ ч Монгол угсаатны соёлд цусан төрлийн холбоогүй хүнтэй ураг барилдах, охиноо айлд өгөх, айлаас бэр гуйх зэрэг ойлголтууд, дээр дурдсан бэрийг хадмын гал голомт, бурхан сахиусанд мөргүүлэх зэрэг ёс заншлын гүнд тотем шүтлэгийн утга агуулга хадгалагдсаар байна.

Австраличууд болон бусад примитив ард түмэнд тотем шүтлэгийн амьтан болон зарим эд материал, юмсын хэрэглээ, нэршил, үйл хөдлөл, ан амьтан, үхэгсэд хийгээд удирдагч, дайсан гээд хорио цээрт хамаарахгүй зүйл гэж үгүй. Хорио

⁸ Түдэв Л. (2016). Цээрлэл зүй. Улаанбаатар. х.74

⁹ * Ухамсаргүй дур хүсэл, айдсыг сэдээсэн сэтгэл хөдлөлийн яг тэр объектод биш, өөр аюул багатай эсвэл орчиндоо болон бусад зүйлээр орлуулах байдлаар хүслээ илэрхийлэх ба айдсаа нимгэлж тайвшрах, таашаал авах, хамгааллын механизм.

¹⁰ Түдэв Л. (2016). Цээрлэл зүй. Улаанбаатар. х.75

¹¹ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.2

¹² Мөн тэнд. х.10

¹³ Монгол Улсын угсаатны зүй. (2012). Монгол улсын шинжлэх ухааны академи. I боть. Түүхийн хүрээлэн. х.338

цээрт хамаарч буй дээрх бүхэнд ид шидийн “mana” хүч байдаг гэж итгэдэг учир тэдэнд асар их айдас байдаг. Ийм айх, ичих сэтгэл зүй тэдний амьдралыг бүхэлд нь тодорхойлдог. Тэд байгалийн сүр хүчинд ихээхэн өртдөг, түүнээс айх айдастай байсан хэдий ч ийнхүү айдас нь хорио цээрийг зөрчих дур хүслийн хорхойслоос айх айдсаас хэзээ ч илүү гарч байгаагүй гэж З.Фрейд үздэг. Өөрөөр хэлбэл, тэдний амьдралд хорио цээрт хамаарахгүй зүйл гэж бараг үгүй бөгөөд, хорио цээрт хамаарч байгаа бүхнийг үнэмлэхүй дээд хүчтэй гэсэн итгэл бүрэн дээд хэмжээнд байжээ. З.Фрейдийн үзсэнээр неврозтой өвчтөнүүд ухамсаргүйгээр өөртөө бий болгож буй хориг, примитив ард түмнүүдийн хорио цээр хоёрын нүдэнд тусдаг төсөө нь эдгээр хорио цээр аль нь ч адил үндэслэгээ шалтгаан тодорхойгүй, тэдгээр хорио цээрийг зөрчвөл үнэхээр шийтгэл хүлээх үү гэдэг нь оньсого адил байдаг. “...Зэрлэг хүмүүсийн хориг үйлийн жинхэнэ үндэслэл хийгээд хорио цээрийн жинхэнэ үүсэл гарлын тухай тэднээс асууж, сураглах нь ямар ч утга учиргүй. ...Тэд энэ тухай юу ч хэлж чадахгүй. Яагаад гэвэл тэдний энэ сэдэл «ухамсаргүй шинжтэй» байдаг”¹⁴ гэж З.Фрейд бичжээ. Өөрөөр хэлбэл тэд ухамсаргүйгээр хорио цээрийг даган баримталж, түүнийг зөрчвөл тэсэхийн аргагүй шийтгэл хүлээнэ гэсэн ямар ч нотлогоогүй, хатуу итгэл үнэмшил, айдастай амьдардаг.

Тэд “...үй олон хязгаарлалт, яагаад энэ зүйл, бас тэр зүйл харилцаа хориглогдсон нь тодорхойгүй, энэ тухай бодолэргэцүүлэл тэдний толгойд оржирэхгүй, тэд ийм хорио хязгаарлалтыг тэртэй тэргүй ойлгомжтой мэтээр үзэж захирагддаг”¹⁵ гэж тэрээр үзжээ. Хорио цээрийг ухамсаргүйгээр хүлээн авч байгаа овгийн хувьд нэгэнт дотоод итгэл үнэмшил дээд цэгтээ байдаг учраас тэдэнд хориог хатуу чанд мөрдөж буйн утга учир дэндүү ойлгомжтой. Ер нь эртний хөгжлийн түвшин дэх ард түмний хувьд төдий биш, хорио цээр, зан үйлийг дагаж мөрдөж буй өнөөгийн аливаа ард түмний хувьд ч сэтгэл зүйн ийм хууль үйлчилж байдаг гэж үзэх бүрэн үндэстэй. Учир нь, цээрлэх ёс бол хүн ёсны харилцааны нэгэн чухал хэсэг бөгөөд зүгээр нэг хэм хэмжээг сахиулах өнгөц зорилготой бус, цаанаа хүний сэтгэлийн дотоод итгэл үнэмшилтэй нягт уялдсан байдгаараа оршихуйн утга холбогдолтой. З.Фрейдийн бичсэнээр “... энэ бүх цээрийн үндэс нь нэг төрлийн онол мэт тогтсон итгэл үнэмшил байдаг, хүний дотоод их хүчнүүдэд тулгуурладаг учраас хориг үйлдлийг хүлээн авч”¹⁶ санаандгүй зөрчвөл айж эмээснээсээ болоод сэтгэл зүйн хүчтэй цохилтод орж үхэх тохиолдол ч байдаг ажээ.

Онгон шүтлэг ба хорио цээр” зохиолд бичсэнээр австралид хориотой омгийн этгээдтэй бэлгийн харилцаанд орвол шийтгэл нь ерөөсөө цаазын ял байдаг. Ийм ял хүлээж буй нь овгийн шүтээний “mana” хүчний шууд шийтгэл биш, харин овгийн шүтээний өмнө хорио цээр зөрчснөөс айсан тухайн овгийн гишүүдийн гэмт этгээдэд оноож буй шийтгэл юм. Хориог зөрчсөн гэмт этгээдийг хатуу шийтгэснээр овогт тохиолдсон нүглийг шүтээний өмнө гэмшин наманчилж, ингэснээр дээд хүчний аймшигт шийтгэлээс овгийг аварч болно гэж зэрлэг хүмүүс итгэдэг байна. Хэн хорио цээрийг зөрчинө, түүнийхээ улмаас тэр өөрөө тотемын өмнө үнэхээр цээрлэл хүлээдэг үү гэдэг асуудалд тэдний гүн бат үнэмшлээс өөр нотлох үндэслэл байдаггүй. Тийм боловч энэ нь нийгмийн зохион байгуулалтын хувьд ч, сэтгэл зүйн хувьд ч хүчин төгөлдөр хууль мэт хатуу чанд үйлчилдэг нь сонирхолтой бөгөөд

¹⁴ Фрейд З. (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.28

¹⁵ Мөн тэнд. х.26

¹⁶ Мөн тэнд. х.26

хачирхалтай. З.Фрейд хүн төрөлхтний зан заншил дахь хорио цээр, нийгмийн хууль цааз нь эртний табугаас эх сурвалжтай гэж үзэхдээ "...хорио цээр нь манай хуулиудын шаардлагуудын үндэс болдог"¹⁷ гэж тэмдэглэсэн. Эрт үеийн хууль цаазын сэтгэлгээнд агуулга хэлбэрээ өөрчилсөн табугийн хатуу чанд байдлын ул мөр нэлээд байсан гэж үзэх үндэслэл бий. Тухайлбал, Монгол улсын төрийн цааз хууль "Их засаг" байх үед энэхүү хуульд хатуу хууль цаазын заалтууд байжээ. "... их засаг хуульд харц ардыг нэг аравтаас нөгөө аравтад, нэг зуутаас нөгөө зуутаг дур зоргоороо шилжхийг хатуу хориглож, зөрчсөн хүнд шууд алах ял оноохыг заажээ. ... Алах ялыг хааны зарлиг биелүүлээгүй, адуу хулгайлах, ахмад хүнийг хүндлээгүй, аливаа хүн усанд болон үнсэнд шээснийг цаазалсугай хэмээн заажээ"¹⁸ гэснээс үзэхэд балар эртний табу ихээхэн өөрчлөлтийг туулж, хожуу үед нийгмийн харилцааны зохицуулалт болж хууль цаазын үндсэнд шингэн үлджээ.

З.Фрейд хорио цээрийн бодит байдлын талаар бичихдээ табугийн хоригууд нь аливаа үндэслэгээнээс ангид байдаг. Тэдний гарал үүсэл нь тодорхойгүй, эдгээр нь бидний хувьд ойлгомжгүй ч эрхшээлд нь байгаа хүмүүст дэндүү ойлгомжтой мэт байдаг гэсэн бол, Вундт хүн төрөлхтний хамгийн эртний бичигдээгүй хууль зүйн кодекс бол табу гэжээ. Нэгэнт үндэслэгддэггүй юм бол эдгээр хорио цээр ямар уг сурвалжаас гаралтай болох тухай асуудал гарч ирнэ. З.Фрейдийн тайлбараар, "... хорио цээрийн жинхэнэ эх сурвалжууд хамгийн урт хугацааг эзэлсэн примитив хүний дур хүслүүд хаанаас эхлэлээ авч байна, тэндээс үүсдэг, өөрөөр хэлбэл, чөтгөр шулмын хүчнүүдийн үйлчлэлийн өмнө айн дагжих айдсаас хорио цээр үүсдэг"¹⁹ гэжээ. Шууд утгаараа хорио цээр айдас дээр суурилан үүсжээ. Хүний сэтгэцийн хамгийн эртний бараг анхдагч хариу үйлдэл бол айдас юм. Айдас бол нэг талаас хүний бодит ахуйтайгаа харьцах явцад үүссэн туршлагаас өмнө хүнд өөрт нь байдаг экзистенциаль түгшүүрээс эх сурвалжтай гэж З.Фрейд үздэг. Энэ утгаар айдас хүний оршихуй ба бодит ахуйтай нягт холбоотой болохоор хүнд айдас төрүүлэхгүй зүйл гэж бараг үгүй. Тэгвэл хорио цээрийн уг гарлыг хэрхэн тайлбарлах тухай З.Фрейд "... зугаацал таашаал ч тэр, хориг үйл ч тэр дур хүсэлд хамаатай, хориог зөрчих гэсэн дур хүсэл, хүслээ биелүүлснээр бий болох таашаал ханамж ба айдас гэсэн үзэгдлүүд нь сэтгэцийн гүний зөрчлийг үүсгэж байдаг"²⁰ гэж ухамсаргүйтэй холбон үзсэн. Нэг үгээр хэлбэл айдас ч тэр, хориотой зүйлийг илүү ихээр шохоорхох дур хүсэл ч тэр ухамсаргүйгээс үүдэлтэй гэсэн санааг илэрхийлжээ. Хориотой зүйлээс айхын зэрэгцээ түүнд илүү их татагдах ухамсаргүй хүчний нэгэн бодит жишээ бол хүүхэд «болохгүй» гэж хориглосон зүйлийг заавал шохоорхож, нууцаар олж мэдэхийг оролддог тийм нэг үзэгдлээр илэрдэг.

Эртний хүмүүст айдас төрүүлдэг олон хүчин зүйл байсан. Хүн төрөлхтний түүхийн үүр гэгээрч байх үед хүмүүс юмсын учир шалтгааныг байгалийн зөнгөөрөө мэдэрч харилцдаг байсан гэдэг. Тэр үед юмсыг шинжлэн судлах чадал байсангүй учир айдас төрүүлдөг юмс болон ариун нандин эсвэл бузар гэсэн бүхэнд хорио тогтоодог байжээ. Хорио тогтоосон хэдий ч хүнд хориотой зүйлийг (*хориотой амьтны мах, хориотой газрын жимс идэх, хориотой овгийн гишүүнтэй харилцаа үүсгэх гэх мэт*) зөрчиж, түүнээс таашаал ханамж мэдрэх гэсэн ухамсарлагдаагүй

¹⁷ Мөн тэнд. х.3

¹⁸ Аръяасүрэн Ч., Нямбуу Х. (1992). Монгол ёс заншлын их тайлбар толь. Боть I. Улаанбаатар. х. 95

¹⁹ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.21

²⁰ Мөн тэнд. х.26

хүсэл сүлэлдсээр байдгийг З.Фрейд сэтгэцийн хоёрдмол хуулиар тайлбарладаг. Энэ талаар З.Фрейд бичихдээ; "...хорио цээр ганхашгүйгээр оршин байгаа баримтаас нэг зүйл санаа урган гардаг. Энэ бол мөнөөх хориотой зүйлийг хийснээр олж авч болох зугаацал, таашаалын хүсэл нь хорио цээрийг баримтлагч ард түмэнд ч оршин байдаг гэх явдал юм. Тэд табугийн цээр, цаазад хандсан харилцааны хувьд хоёрдмол чиг хандлагатай. Тэд ухамсаргүйдээ мөнөөх цээрийг зөрчихийг улам ихээр хүсэж байвч түүнээсээ айцгаадаг. Тэд ийн зөрчихийг хүсэхэд айдас нь таашаалаасаа хавьгүй илүү их байдаг учраас л тэд айцгаадаг"²¹ гэжээ. Тийнхүү хүсэл хичээн хүчтэй байсан ч айдас түүнээс илүү хүчтэй аж. Эртний хүмүүст үлэмж айдас байсан, тэд аюулгүй зүйлийг ч аюултай мэтээр төсөөлж аврал, өршөөл эрдэг эсвэл хорио цээр тогтоодог байжээ. Хүмүүс ертөнцийг амьтай, сүнстэй гэж төсөөлөн түүнд холбогдох үйлдэлд хорио цээр тогтоохын хамт аргадаж гуйх ёслол үйлүүд үүссэн байна. Ийм сүсэг бишрэлийн ёслолын хэлбэрүүд нь айх айдсийг нимгэлж, цаашдын шашны янз бүрийн зан үйлээр дамжин соёлын элементийг бүрдүүлжээ.

Хорио цээр гэдэг нь хэд хэдэн утгаар ойлгогддог гэж З.Фрейд үзсэн. Үүнд; "...хүмүүс эсвэл юмсын ариун нандин эсвэл цэвэр бус, бузартай шинж тэмдэг, энэхүү шинж тэмдгээс үүдэлтэй хязгаарлалтын төрлүүд хорио цээр болдог"²² Ариун нандин гэдэгтэй холбогдож байгаа хязгаарлалт бол, жишээ нь, овгийн элэнц, өвөгтэй холбогдсон амьтны амийг үл бүрэлгэх, холбогдох таашаал ханамжаас татгалзах тэвчихийн хэлбэрүүд юм. Харин цэвэр бус, бузартай холбогдсон хязгаарлалтад хориотой омгийн гишүүдийн инцесс үүсэх болон үхэгсдийн сүнс, ад зэтгэрийн хорлолтой гэх зүйлээс татгалзах тэвчээр хамаарагдаж байна. Дээрх хориог зөрчсөний улмаас үүсэж буй бузар гэж үзэгдэх явдал өөрөө мөн хорио цээр гэсэн ойлголтод хамаардаг ажээ. Жишээ нь, үхэгсдийн үйлд биеэр хүрэлцсэн хүмүүст бузар шингэсэн байдаг гэдгээс тухайн хүн тодорхой хугацаанд өөрөө хорио цээртэй зүйлд хамаардаг.

Улмаар хорио цээрт хүрсэн, түүнд холбогдолтой үйл хийсэн байдлаар нь ямар нэгэн хүн ба юманд байдаг жам ёсны «тапа» хүчтэй холбогдсон шууд хорио цээр, мөн тэрхүү далд хүчнээс үүдэлтэй хувраг, удирдагчдын (тапа) хүчтэй холбоотой үүсэх дамжсан хорио цээр гэж З.Фрейд нарийвчлан авч үзжээ. Жам ёсны хорио цээр гэдэгт үхэгсдийн сүнс болон бусад ид шидийн хүчтэй орон газар, ургамал, амьтныг ойлгодог бол дамжсан нь лам хувраг, удирдагчдыг ид шидийн (тапа) хүчтэй гэж итгэхтэй холбогдон хорио цээр үүсдэг. Примитив ард түмний хувьд энэ бүхэн гүн гүнзгий айдас төрүүлдэг. Сэжиг төрүүлэгч айдас хаанаас яагаад бий болдог вэ гэсэн асуулт зүй ёсоор гарч ирнэ. Монголчууд айхгүй ч гэсэн аягүй гэж ярьдаг. Аюулгүй гэдгийг мэдсээр байхад аягүй сэтгэл төрүүлэгч шалтгаан нь чухам юу вэ гэсэн асуулт тавьхад хариулт нь олдохгүй. З.Фрейд үүний шалтгааныг ухамсаргүйгээс хайх хэрэгтэй гэж үзсэн юм. Хүн ерөнхийдөө аливаа зүйлээс болгоомжилсон байдлаар далд айдас дагуулж явдаг. Өөрөөр хэлбэл, хий айдас үүсэх суурь түгшүүр хүний ухамсаргүйд бэлхнээ байдаг гэсэн санаа З.Фрейдийн үзэлд байх бөгөөд гадаад нөхцлөөс үүссэн айдас ч ухамсаргүйд түрэгддэг гэсэн нь бий.

К.Г.Юнг (1875-1961) айдсын мэдрэмжийг бүр бага наснаасаа өөрийн биеэр

²¹ Мөн тэнд. х.28

* К.Г.Юнгийг бага байхад Рейне хэмээх хурхрээний дээхэн байрлах шигтгээн дэх санваартны гэрт тэднийх амьдардаг байжээ.

²² Юнг К.Г. (2001). Психология бессознательного. Москва. с.18)

туулсан тухайгаа өгүүлсэн нь бий. К.Г.Юнг бага байхдаа их айдаг хүүхэд байснаас нь товч дурдвал; "... шөнө биеэсээ салсан толгой биеэсээ түрүүлэн хөвж яваа ер бусын үл ялиг гэрэлтсэн дүрс ээжийнх нь өрөөнөөс гарч явахыг харах, Рейне²³ хүрхрээнд цохигдсон хүмүүс живэн, цогцсууд нь хад чулуунд цохигдоно. Энэ хүрхрээ надад маш их айдас төрүүлдэг. ...Би шөнийн тодорхойгүй байдал, харанхуйгаас их айдаг байлаа. Амьдралын турш намайг зовоосон зүүд, ... дахиж ийм зүүд зүүдлэхвийдээ гэхээс орой унтахаасаа ч айдаг байлаа"²⁴ Ээж надад залбирал, ёслолын үйл зааж өгч өөрөө ч залбирал үйлддэг байсан ба энэхүү залбирал нь намайг тайтгаруулж тэр айдсыг мартуулж байсан юм гэж К.Г.Юнг дурсан бичсэн байдаг. Эдгээр бүхнээс философи дүгнэлт хийхэд үхлийн зөн бэлгэ, айдас зэрэг бол хүний ахуйн үндсэн нөхцөл, ухамсаргүйн нэг тодорхой элемент юм.

Эртний ард түмний хувьд айдас зарим тохиолдолд бодит шалтгаантай ч ихэнхдээ сүсэг бишрэлд суурилсан төсөөллийн айдаст автдаг байжээ. З.Фрейдийн үзэж байснаар ийм айдсын мэдрэмж нь хүнийг үхэлд ч хүргэдэг эрсдэлтэй бөгөөд хүмүүс өөртөө холбогддог хорио цээр барьж, улмаар сүсэглэл, наманчлалын ёслол үйлдсэнээр сэтгэл санааны хувьд тайвширлыг олж, айдсаас зохих ёсоор ангижирдаг. Тэд төсөөлөлд итгэдгээсээ болоод зарим тохиолдолд айж үхдэг. "«Мана» хүчийг агуулдаг ид шидтэй гэдгийг мэддэггүй байснаасаа болж санаандгүй цээрийг зөрчсөнөө мэдээд айдсаасаа болж үхсэн тухай лавтай баримтууд байдаг. Жишээ нь, хорио цээртэй амьтны мах идсэн гэнэн этгээд гүн гутралд орж үхлээ хүлээн, тэгээд үхсэн"²³ баримт З.Фрейд дурдсан байна. Үхлийн шалтгаан нь ямар нэг хүчний шийтгэл бус, харин "мана" хүчний шийтгэл ирнэ гэж сэжиглэн айсан айдас байдаг. Ийм итгэл үнэмшил, сэжигтэй хүмүүс айснаасаа болж маш хүчтэй цохилтод ордог аж. З.Фрейдийн дүрсэлснээр хорио цээр зөрчсөн гэж айж буй хүмүүсийг цахилгаан цэнэгт цохиулсан амьд биетэй харьцуулж болох юм. Цахилгааны гүйдэлд цохиулсан организм мөнөөх хүчийг сөрөн зогсоно гэхэд дэндүү сул байдаг шиг айдас тийм хүчтэй цохилт болдог.

"...Шинэ Зеландад эрхэм дээд хүндэтгэл зэрэгмжийн нэгэн удирдагч нэг удаа зам зуураа хоолныхоо үлдэгдлийг мартжээ. Тэгтэл нэгэн эрүүл бие бялдар бүхий залуу боол хүрч ирж гэнэ. Өлссөн залуу үлдэгдэл хоолыг гавшгайлан иджээ. Тэрээр дөнгөж идэж дуусаж байхад хажуухнаас нь харсан этгээд удирдагчийн хоолонд халдах үйл хийсэн тухай ухаангүй айн хэлжээ. Боол хэдийгээр эрүүл, эрэлхэг дайчин байсан ч энэ мэдээг сонсуутаа газар унаж, аймшигтайгаар татганаж байснаа маргааш өдрийнх нь орой нас баржээ"²⁴ гэснээс үзэхэд дотоод хүчинд тулгуурладаг учир айдас маш хүчтэй илэрдэг. Ер нь хүнд гэнэтийн явдлыг сонсмогцоо цочролд орж цахилгаанд цохиулах адил үхдэг тохиолдол бий (*Гэхдээ үүнийг манай хэлэнд харвах, зүрх зогсох зэргээр тайлбарладаг.*)

Удирдагч ба тодорхой хүнд тийм ер бусын хүч буй гэх үнэмшил газар орон бүрд байдаг бололтой. "... дорнод Африкийн ойрмог, үржил шимтэй муж Джебе-Нубагийн оршин суугч негрүүд удирдагч-илбэ тахилчийн гэрт орвол үхэл ирдэг хэмээн итгэдэг. Тэд зүүн мөрөө ил гарган удирдагчийг гараа хүргэн соёрхохыг гуйж байдаг. Удирдагч гараа хүргэвэл гэрт орсны төлөө оногдох шийтгэлээс зайлсхийх учиртай. ...Удирдагч хувьдаа хэрэглэхээр сонгосон чулуун дээр хэн нэгэн суух аваас жилийн дотор энэ этгээд үхэх болдог"²⁵ гэсэн баримтуудыг дурджээ. Эдгээрийн адил

²³ Фрейд З. (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар, х.19

²⁴ Фрейд З. (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар, х.38

“mana” хүч гагцхүү лам хувраг эсвэл бөө, домч гэх мэт хүнд байдаг гэсэн итгэл манай соёлд нэлээд гүнзгий ул мөрөө үлдээсэн гэж болно. Удирдагч, санваартан онцгой хүмүүс ид шидийн бөгөөд аюултай хүчийг тээж явдаг, тэр хүч нь цахилгаан гүйдэл цохих адил хүрэлцэх төдийд л хэн бүхэнд үхэл, сүйрэл авчирдаг гэж Австралийн овгийнхон үнэхээр итгэдэг. Ийм мэт аюулаас зайлсхийхийн тулд хорио цээрийг ягштал мөрддөг ба хориог зөрчсөн тохиолдолд наманчлах тодорхой ёслол, зан үйлийг хийх шаардлага тулгардаг байна. “...айдаст бодол санааны зарим хэсгийг нь зайлшгүй хийх учиртай тодорхой үйлдлүүдийг гүйцэтгэснээр даван гарч болдог. ...ийм үйлдлүүд нь мөн чанарынхаа хувьд гэмшил наманчлал, хамгаалалтын болон цэвэршил ариуслын арга хэмжээнүүд байдаг нь ямар ч эргэлзээгүй. Зөрчсөн үйлдлийг ийм маягаар «ёслол үйл»-ээр эерүүлж наманчилж болдог ба үүнийг онцгой эрхэм зүйлд тооцдог”²⁵ гэж З.Фрейд “Онгон шүтлэг ба хорио цээр” зохиолдоо бичсэн байдаг. Айснаас болж өөртөө зориулж зан үйл бүтээгээд ёслол үйлээр айдас гэмшлээ наманчилдаг шүтлэгийг примитив ард түмний олон үйлдлээс харж болох юм. Энэ үүднээс нь З.Фрейд шүтлэг бол хүнд сэтгэл зүйн тайтгарлын нөлөө үзүүлдэг ач холбогдолтой гэж үнэлж байв.

Овгийн ард түмний хувьд үхэгсэд хүчирхэг захирагчид болж байдаг нь илэрхий юм. Тэдэнд сүнснээс сэжиглэх, айх айдас дэндүү их байдаг учир үхэгсдэд биеэр хүрч холбогдох үйл үүссэний дараах хорио цээрийн зан үйлүүд Полонез, Меланези даяар, мөн Африкийн зарим хэсэгт нэгэн адил байдаг. Ганцхан жишээ татахад “...маори нарын хувьд шарилд хүрсэн, эсвэл оршуулганд оролцсон хэн бүхэн их бузартдаг, бусад хүмүүстэй харилцах түүний харилцааг бараг тасалдаг. ...Тэрээр ийм бузрыг бусдад халдаахгүйн тулд ямар ч хүнтэй, ямар ч эд юмстай ойртож болохгүй. Тэр ч байтугай хоол унданд гараа хүргэж болохгүй, түүнд хоолыг тавьж өгөх ба уруул, амаараа идэхээс өөр аргагүй. ...Тусгаарлах хугацаа өнгөрөхөд хүүрээс бузартсан этгээд дахин нөхдийн дунд ирэх бололцоотой”²⁶ болдог. Тэгэхдээ хорио цээртэй үед хэрэглэж байсан бүх зүйлийг нь устгадаг. Хорио цээрийн тийм ёс журмыг зөрчсөн хэн боловч хүндээр өвчлөх, улмаар үхэх ёстой гэдэгт зэрлэг хүмүүс үнэн сэтгэлээсээ итгэдэг ажээ. Тэд хэзээ ч хориог зөрчиж зориглохгүй тийм хэмжээнд итгэл үнэмшил нь ганхашгүй байдаг хэмээн нэгэн ажиглагч тэмдэглэсэн нь үнэхээр сонирхол татаж байна гэж З.Фрейд бичжээ. Эдгээр ард түмэнд талийгаач хэдий ойр дотнын хүн байсан ч үхсэн л бол түүнийг ариун бишид тооцож, жигшиж буй нь тэдний сүнснээс айх айдастай холбоотой байдаг. Тэд талийгаачийн сүнс нь амьд үлдэгсдэд заналхийлж хор учруулна хэмээн итгэдэг байна. Тухайлбал, “... хойд Америкийн овгийн бэлэвсэн эхнэрүүдийн зан үйл ёсоор нөхрөө нас барсны дараа бэлэвсэн эхнэр сүнсэнд танигдахгүйн тулд хуурай өвсөөр хийсэн хувцас өмсдөг. Яагаад гэвэл, талийгаачийн сүнс нь гашуудлын хугацаанд ойр төрлийнхөөсөө холдохгүй, зогсолтгүй тойрон эргэлдэж, тэдэнд санаархаж байдаг”²⁷ гэж үздэг. Сүнс биед байхдаа амьдарч байсан орон, ойр дотнынхоо хүмүүст хоргодож болзошгүй гэсэн айдас тэднийг ийн зовоодог гэж З.Фрейд тайлбарлажээ.

Түүний авч үзсэн дараагийн нэг баримт бол “...Филиппины нэгэн аралд амьдардаг Агутаинос нарт байх ёс заншлаар, бэлэвсэн эхнэр нь нөхрөөсөө хойших эхний долоо, найман өдөр урцаасаа гардаггүй, харин гагцхүү шөнө л ямар ч

²⁵ Фрэйзер Ж.Ж. (2011). Алтангишүү. Орч. Ж.Отгонбаяр. Улаанбаатар. х. 224

²⁶ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.25

²⁷ Мөн тэнд. х.47

болгоомжлолгүйгээр гардаг. Тэр эмэгтэйг харсан хүн агшин зуурт үхэх аюулыг өөртөө дууддаг, тийм ч учраас энэ эмэгтэй модон саваагаар мод цохиж өөрийнхөө ойртож ирж буйг сануулдаг”²⁸ Энэ цээрийн далд утга нь эхнэрт нөхрийн сүнс хоргодсон байх магадалтай ба ямартай ч гашуудлын хугацаанд нөхрийн сүнс түүний дэргэд байгаа гэсэн санааг илэрхийлдэг бололтой. Гэхдээ тэдний амьдрал дахь бүх хорио цээрийн утга учрыг сүнснээс айх айдастай холбогдсон хорио төдийхнөөр хязгаарлах боломжгүй нь мэдээж юм. Сүнсэнд итгэх шүтлэг бол сүнс мөнх тухай номлодог шашинд бүрд зайлшгүй байдаг.

Тухайлбал буддын шашинт монголчуудад сүнс, хойд насны амьдрал, төрөл арилжих тухай итгэл үнэмшилтэй холбоотой хүн үхсэний дараа сүнсэнд зориулсан тодорхой зан үйлүүд хийх нь түгээмэл билээ. Үхлийн тухай мэдээг агуулсан “Чойжид дагинын тууж” хэмээх шастирт талийгаачийн сүнс нь гашуудлын хугацаанд ойр төрлийнхөөсөө холдохгүй байж буйг харуулдаг. Тэрхүү Шастирт Чойжид хэмээх нас барсан бүсгүй ийн өгүүлж буй нь: *“... дээрээс олон амьтан дарсан мэт аюул болсны дараа хөлгүй их далай дор орж, маш даарч хөрсөнд биед минь хөлдөхийн цаглашгүй зовлонг амсав. ...газар дэлхий урван хөрвөх мэт болж хүржигнэх их дуу чимээ болсноор би юу ч үл санан бие сэтгэл амар жимэр болов. ...аюумшиг бүхэн үүл бороо цэлмэн арилсан мэт хоосрон замхарсанд миний сэтгэл аюуж эмээхийн зовлонгоос амирлаваа. Тэндээс өөрийн ор дэвсгэр тийш харвал муухай өмхий үнэр ханхалсан нэгэн үхдэл мэлхийг миний хувцсаар бүтээснийг үзэв. Охин, хүүхэд ба ураг төрөл айлын ахан дүү нар ирээд зарим нь тэрхүү үхдлийн биенээс барьж, зарим нь аманд нь амаа хүргэн орлин уйлцгааж байх нь мянган луу нэгэн цагт хүрхрэх адил болов”*²⁹ Талийгаачийн бие үхсэн ч сүнс эс үхдэг ба улмаар сүнс амьдарч байсан уг газраа оршиж буйг илэрхийлсэн энэ мэдээ нь дээрх зохиолд дурдсан эртний олон ард түмний сүнсний тухай итгэл үнэмшилтэй нэгэн утгатай юм.

Сүнс хоргодох тухай асуудал ч мөн угсаатнуудын итгэл үнэмшил дэх нийтлэг ойлголт юм. Дурдан буй шастирт: *“Манайд зургаан байшин дүүрэн арвай байв. Түүнээс айлуудад өгч байхыг хараад эд нар юу хийнэм хэмээн хармын сэтгэл надад төрж, миний бие эдгэрч гэхээс биш үхэж гэх сэтгэл эс төрнө”*³⁰ Гэснээс үзэхэд хүний сүнс энэ ертөнцөөс явсан гэдгээ хүлээн зөвшөөрч чаддаггүй байх магадал өндөр байдаг ажээ. Талийгаачийг хүмүүс хардаггүй боловч тэнд болж буй үйл явдлыг сүнс харж, төрөл төрөгсөддөө гомдох, эд зүйлс, амьдарч байсан орчиндоо хоргоддог гэх нь аливаа ард түмний нийтлэг итгэл үнэмшил байж болох юм. Хэрэв сүнс биеэсээ салсан хойно амьдралд татагдаж эд юмс, эхнэр хүүхдэдээ хоргодоод байвал зуурдын ертөнцөд гацаж төөрөн, хорлолт муу сүнс болж, ойр тойрондоо гай хүргэдэг гэж янз бүрийн шашинд үздэг байна. Чойжид дагинын туужид өгүүлснээр Чойжидын сүнс өөрийн биеэс айж, цочирдож байдаг.

Монгол угсаатны хувьд талийгчийн сүнснээс цэрвэх айдсын мэдрэмж байдаг нь ерийн зан үйл болон шашны илэрхийлэлтэй холбогдон эдүгээ ч хадгалагдан, оршуулгын зан үйлд илэрсээр буй. Монголчуудад оршуулгын газраас буцаж ирэхдээ эргэж хардаггүй, оршуулгын газрыг гурван жилийн дараа эргэдэг гэх зэрэг зан үйлүүд байдаг. “Оршуулгад оролцогсдыг буцаж ирэхэд галын цог дээр утаа униар

²⁸ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар х.48

²⁹ Мөн тэнд. х.48-49

³⁰ Чойжид дагинын тууж. (2009). Мунхагийн харанхуйг гэрэлтүүлэгч билгийн оршвой. Улаанбаатар. х.17

уугиулж, үүний дундуур оршуулгад явсан унаа тэрэг, хүмүүс бүгд орж ариулдаг”³¹ нь уг газраас элдэв муу ёрын зүйлс (сүнс) дагалдан ирсэн бол түүнийг галын хүчээр устгаж, үлдэн хөөнө гэсэн утгыг агуулж байдаг. Шарил залсан хүмүүс эргэхдээ очсон замаараа явдаггүй. «Хар мөрөө дагахгүй» хэмээн шарилыг нар зөв эргэж өөр зүгт эргэж харалгүй буцдаг.

З.Фрейд “Онгон шүтлэг ба хорио цээр”- бүтээлдээ бичсэнээр “... тэд (примитив хүмүүс) талийгаачийн сүнс байж байгаа бөгөөд эргэж ирэхээс нь айж байгаагаа огт нуудаггүй, үүнийг хөөж явуулах, алс хол байлгахын тулд зөндөө олон ёслол үйл гүйцэтгэдэг. Талийгаачийн нэрийг дуудан хэлэх нь түүнийг дуудан ирүүлэх шившлэг дуудлага мэт тэдэнд санагддаг. Тийм учраас мөнөөх дуудлагаас зайлсхийхийн тулд бүхнийг маш тууштай гүйцэтгэдэг. Тэд сүнсэнд танигдахгүйн тулд хувцсаа сольж, талийгаачийн нэрийг эсвэл өөрсдийнхөө нэрийг өөрчилдөг.”³² Жишээлбэл “... Африкийн Масау нар талийгаач болсных нь дараа нэрийг нь шууд өөрчлөх байдлаар гарц олжээ; нэгэнт бүх хорио урд өмнийн нэртэй холбоотой байсан болохоор сольж хэрэглэж буй шинэ нэрээр түүнийг ямар ч айдас хүйдэсгүйгээр нэрлэж болдог. Ингэхдээ шинэ нэрийг сүнс танихгүй, тиймээс үүнийг тэрээр хэзээ ч мэдэхгүй гэж үзэцгээдэг. Аделандын арлуудын австрали омгууд болон Енкунтер Бару нар хэн нэгнийг үхсэний дараа түүнтэй адил, эсвэл төсөөтэй нэртэй хүмүүс бүгд нэрээ өөрчлөх байдлаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэлээд тууштай хэрэгжүүлдэг. ...Хэн нэгний үхлийн дараа талийгаачийн нэртэй адил эсэхийг үл харгалзан түүний бүх төрөл төрөгсдийн нэрийг сольцгоодог.”³³ Талийгаачийн сүнснээс айх айдас бүрэн утгаараа байдгийг энэ мэт мэдээ гэрчилж байна. Талийгаачийн нэрийн хорио цээр бие биенээсээ дэндүү алс хол орших өвөрмөц шинжтэй ард түмэнд нэн тархмал байдаг гэж З.Фрейд үзээд монголчуудыг дурдсан нь бий. “...талийгаачийн нэрийг хэлэхгүй байх хориг тун чанд хатуу. Өмнөд африкийн зарим овог амьд үлдэгсдийнх нь дэргэд талийгаачийн нэрийг хэлэх хамгийн том доромжлол болдог. Үүний төлөөх шийтгэл нь аллага үйлдсэнд оноох шийтгэлээс дутуугүй чанга байдаг.”³⁴ аж.

Авсралийн уугуул овгуудын дунд хэрэглэгдэж буй шиг талийгаачдын нэр цээрлэх ёс Монголчуудын итгэл үнэмшилд нэлээд ул мөрөө үлдээсэн. Гэхдээ манайд буй нэрийн цээрийн утга нь зарим талаар талийгаачийн сүнстэй холбоотой ч нөгөө талаар хүндэтгэлийн санааг агуулдаг соёлын нэг өвөрмөц илрэл гэж үзэж болно. Монгол судлаач П.Карпины тэмдэглэхдээ “... талийгаач бологсдыг хүндэтгэх, сүнсийг нь амар амгалан байлгах үүднээс нэрээр нь дууддаггүй, өөрөөр эерүүлж нэрлэж иржээ. Монголчуудад нэрийг цээрлэх нь XIII зууны үед ч мөн байжээ. ... талийгаачийг гурав дахь үеийнхэн нь хүртэл нэрлэж дуудахыг цээрлэдэг”³⁵ гэж тэмдэглэжээ. Л.Түдэвийн бичсэнээр “нөгцөгсдийн үр хүүхэд нь гурван үе болтлоо нэрийг дурдаж, дууддаггүй, “*намайг дуудаж байна*” гэж өндийн босч үйл тамаа бардаг гэдэг. Тиймээс бурхан өвөг, бурхан аав, бурхан болооч гэхчлэн хэлнэ” гэж тэмдэглэсэн. Харин А.Пунсаг номондоо бурхан болооч, өөд болооч, талийгаач, арилаач, бүрлээч гэх мэт нас барсан хүнийг дурсах тавь гаруй цээр нэрийг дурдсан. Энэ нь хожуу үед талийгаачийг нэрийг өөр нэрээр эерүүлж дуудах нь улам их болсоныг илэрхийлнэ.

³¹ Мөн тэнд. х.18

³² Пунсаг А. (2012). Монголын нууц товчоон дахь ёс заншил, зан үйлийн тайлбар толь. х.108

³³ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.52

³⁴ Мөн тэнд. х.50

³⁵ Мөн тэнд. х.47

Сүнснээс айх айдстай холбогдох хорио цээр, түүнийг эерүүлж зөөлрүүлэх ёслол үйлийг гүйцэтгэсээр ирсэн сүнсний хорлолоос хамгаалж, зайлуулах утгатай, дотоод тайвширлыг олж байгаа нь эдүгээ ч бидний ухамсаргүйн илэрхийлэл болж байдаг.

Овоо, уул ус тахих ёс бол тотем шүтлэгээс үүдэлтэй бөгөөд уул ус, хангай дэлхийг эзэн савдагтай гэж үзэх шүтлэгтэй холбоотойгоор төлөвшсөн байна. "...эртний хүмүүст өөрт нөлөөлж буй далдын хүчийг муу сүнс, сайн сүнс гэж хуваан сайныг нь аргадан тахиж, муу сүнсийг нь зайлуулах янз бүрийн ёслол бий болсон гэж тайлбарладаг"³⁶ гэж Фрейзер "Алтан гишүү" номондоо бичсэн. Манай хэлэнд муу сүнс гэх ойлголт нь буг чөтгөр, ад савдаг, газрын гүйдлийг дарах гэдэг бол, сайн сүнс нь уул ус, газар лусын эзэн, харсан тэнгэр гэх зэрэг хэллэгээр хэрэглэгдэж заншсан гэж болох юм. Зарим угсаатанд уулыг, эсвэл овоог шүтдэг соёлын хэлбэр хадгалагдаж үлдсэн байдаг бол тодорхой ганц мод эсвэл ой модыг шүтдэг угсаатнууд байжээ. Ой модыг бишрэх явдал Европод арийчуудын шашны түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг байна. "...нүүж ирсэн цагаан арьстнууд мод бэлдэж өгөхийг хүсэхэд «диери» нар эрс эсэргүүцдэг байсан гэдэг. Филиппиний арлуудын оршин суугчид өвөг дээдсийнхээ сүнсийг тодорхой төрлийн моднуудад хоргодон амьдардаг гэж итгэдэг. Тиймээс эдгээр модтой болгоомжтой харьцдаг. Модны дэргэдүүр хүндэтгэн мөргөж залбиралгүй өнгөрнө гэж хэзээ ч үгүй. ...Тэд модонд өргөл барьц өргөн барьдаг. Модонд ямар нэг хохирол учруулах нь бүх тосгонд ямар нэг золгүй явдал авчирдаг гэж үзэцгээдэг"³⁷ Ой модорхог газар нутгийн угсаатнуудад мод шүтэх шүтдэг бол монголчууд уул ус, мод, ургамал зэрэг байгалийн үзэгдэл, зарим амьтан зэргийг шүтэж иржээ.

"...сондгой ургасан өнчин ганц мод, булаг усны эхэд ургасан мод, эртнээс нааш цээр, хориотой явсан уул, ус бүхий газрын модонд гар хүрч хөндөхийг хатуу хориглож, ийм мод ургамалд тусгай эзэд оршдог хэмээн төсөөлдөг байжээ"³⁸ Эдүгээ ч энэ итгэл үнэмшил хадгалагдаж, улам бүр соёлын элементийн утга холбогдол бүхий болж байна. Тухайлбал ээж хад, удган модонд мөргөж, хүслээ шивнэх, хадаг, өргөл барьц өргөх зэрээр шашин-соёлын хэлбэрийг илэрхийлж буй. Үүний цаад, гүн учир шалтгаан нь сүсэг бишрэлтнүүдийн дотоод итгэл үнэмшил, магадгүй хүслээ биелүүлэх гэсэн арилшгүй тэмүүлэл, айдас хүйдсээ даван туулах оролдогуудын нөлөө байгааг психоаналитик онолын үүднээс харж болно. Нүүдэлчин монголчуудын сүсэг бишрэлийн хамгийн ойрын баримт бол уул, овоонд идээ, будаа өргөж, аян замынхаа өлзийг даатгадаг. Овооны хажууд дөрөө мулталдаггүй монгол хүн ховор бөгөөд «чухам яагаад» гэдэгт бид уламжлалаас өөр үндэслэлтэй хариулт өгч чадахгүй. Иймэрхүү зан үйлүүд нь бидний шүтлэг бишрэлтэй, тухайлбал уул овооны өөрөөсөө илүү хүч чадалтай эзэн савдагт өөрийгөө даатгах, эцгийн нөмөр нөлөөг санагалздаг ухамсаргүй хүсэлтэй холбоотой гэж З.Фрейд үздэг.

З.Фрейдийн дүгнэлтээр талийгаачийн хойно амьд үлдэгсэд хайртай хүнээсээ хагацсан уй гашуу болохын зэрэгцээ тэдний ухамсаргүйд талийгаачийн сүнснээс айх хоёрдмол мэдрэмж зовоож байдаг гэжээ. "... талийгаачид хандах хайр ба айдас (түүний сүнснээс айх айдас)-ын хоёрдмол мэдрэмж нь түүнийг үхэх үед хоёулаа илэрч байдаг. Энэ хоёр эсрэгцэлийн хооронд мөргөлдөөн үүсэх ёстой. Яагаад гэвэл, тэмцэлдэж буй мэдрэмжүүдийн нэг нь болох айдас бүхэлдээ ухамсаргүйд үлддэг"³⁸

³⁶ Мөнхийн үсэг. (2009) Монгол ёс заншил, зан үйлийн товчоон. х.513

³⁷ Фрейзер Ж.Ж. (2011). Алтангишүү. Орч. Ж.Отгонбаяр. Улаанбаатар. х.15

³⁸ Мөн тэнд. х. 128

З.Фрейдийн үзсэнээр ухамсаргүйд үлдсэн айдас нь талийгаачийн сүнснээс цэрвэх мэдрэмжийг төрөл төрөгсдөд нь бий болгож, түүний тухай амьд сэрүүн үеийнхээс нь өөр төсөөллийг төрүүлдэг. Тэрээр "...амьд үлдэгсэд одоо сүнснээс хамгаалагдах ёстой, тэд дотоод айдсаасаа ангижирсан ч түүнийг гаднаас ирэх аймшигаар сольж орлуулжээ"³⁹ Өөр үгээр хэлбэл, талийгаачийн сүнснээс айх дотоод айдсаа түүнээс хамгаалах гадаад хорио цээр, шашны ёслол үйлийн орлуулгаар сольж өөрсдийгөө тайвшруулах үйл хийж эхэлдэг. Психоаналитик онолд өгүүлдэг хамгааллын механизм ёсоор "...талийгаачийг айдастай зүйл болгон дүрсэлж байгаа **проекц**-ийн үйл явц нь өөд бологчдыг сүнсийг үнэхээр хорлолтой мэтээр буруутгаж болохуйцаар ой дурдатгалд үлдэж хоцорсон бодитой айдсаас дэмжлэгийг олж байдаг гэдгийг үгүйсгэж болохгүй"⁴⁰ Хичнээн ойр дотнын хүн байлаа ч, хэдийгээр өөд болсон нь нэгэнт ойлгомжтой байсан ч, хаа нэгтээ түүний сүнс байгаа гэсэн айдас хүнд ямар нэг байдлаар үлддэг.

Ер нь зэрлэг хүмүүсийн хувьд ертөнц бүхэлдээ амьтай, сүнстэй мэт төсөөлөгдөж, мод болон ургамал ч тийм ойлголтын гадна үлддэггүй байжээ. Австралийн уугуул овогт газар нутаг, ургамал зэрэгтэй холбогдсон айдас нь мөн хорио цээрийг дагуулдаг. Тэд зарим газар, мод ургамал өөрийн гэсэн сүнс буюу бидний хэлэнд заншсанаар эзэн савдагтай гэдэгт итгэдэг. "Маори омгийн нэгэн эмэгтэй ямар ч юм бэ?, үр жимс идээд дараа нь уг жимсийг хориотой газраас авсан тухай мэджээ. Тэгээд тэрээр хориотой газрын эзэн савдаг (сүнс) мэдээж өөрийг нь хөнөөнө хэмээн орь дуу тавин бархирч байгаад төрөл арилжсан байв"⁴¹ Шүтлэгийн ийм хэлбэр нь зан заншилд тодорхой нөлөө үзүүлж ирсэн. Тиймийн учир манайд «сэжгээр өвдөж, сүжгээр эдгэдэг» гэдэг хэлц байдаг. Бас «Гүйдэлтэй газар», «Догшин мод», «Удган мод», «Ээж хад» гэх зэрэг айдас төрүүлэгч, ер бусын ид шидтэй юм бишрэл илэрхийлж байдаг билээ. Гэвч эдгээр нь үнэхээр ид шидийн хүчтэй юу, эсвэл З.Фрейдийн хэлснээр бидний өөрсдөө зохиомлоор амилуулж итгэж үнэмшдэг хуурмаг үзэгдэл үү гэдэгт сүсэг бишрэлийн үүднээс нэг мөр хариу өгөх бололцоогүй. Хорио цээр бол шулмын хүчинд итгэх примитив ард түмний сүсэг бишрэл дээр үндэслэгддэг гэсэн Вундтын үзлийг З.Фрейд онцлоод "... айдас ч тэр, шулмууд ч тэр сэтгэл зүй дэх цаашдын задралд үл өртөх эцсийн шалтгаануудын утгатай байж чадахгүй, шулмууд бодитой оршин байдагсан бол байдал өөр байх байлаа, гэвч шулмууд нь бурхдын адил хүний сэтгэцийн хүчнүүдийн бүтээл болдгийг бид мэднэ шүү дээ; тэд юм юмнаас бүтээгдсэн"⁴² гэжээ. З.Фрейдийн дүгнэлтээр сүнс болон шулам, бурхад зэрэг ойлголт нь ухамсаргүй дахь айдсын нөлөөгөөр хүний сэтгэцэд үүсэж буй хуурмаг төсөөлөл юм. Тийнхүү тэрээр шашны янз бүрийн ёслол, хорио цээрийн олон шинж бүхий зан үйлийн уг гарал нь ухамсаргүйд байна гэж тэр үзжээ.

Аливаа ард түмний шашны зэрэг өвөрмөц ёс заншил, соёл нь өөр өөрийн гэсэн бэлгэдлийн утга агуулгатай. Энэ бүгд ухамсаргүйгээс эх үндсэтэй, ард түмний ухамсаргүйн бүтээл болж байдгийг З.Фрейд, К.Г.Юнг нар сэтгэц шинжилгээний онолдоо тулгуурлан судалжээ. Эдгээр шүтлэг, зан үйл маш бат бэх байдаг тухай тэд

³⁹ Монгол Улсын угсаатны зүй. (2012). I боть. Монгол улсын шинжлэх ухааны академи. Түүхийн хүрээлэн. х.497

⁴⁰ Фрейд З. (2009) Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар. х.56-57

⁴¹ Мөн тэнд. х.60

⁴² Мөн тэнд. х.57

өгүүлж байна. Янз бүрийн ард түмний амьдрал дахь шүтлэгийн хэлбэрүүд хүн гэгч зүйл түүхийн тавцанд гарч ирсэн тэр цагаас бий болж өнө урт цаг хугацааг туулахдаа олон хэлбэрээр өөрчлөгдөж, орлогдсон хэдий ч хүний ертөнцийг үзэх үзэл, оршихуйн салашгүй хэсэг байсаар иржээ. Хүн төрөлхтний түүхэнд гарсан нийгмийн болон техникийн ололтууд нь онгон шүтлэгт нөлөөлснийгөө бодвол хорио цээрийг тун бага өөрчилсөн гэдэг З.Фрейдийн үзэл санааны нотолгоог Монголчуудын амьдрал, итгэл үнэмшлийн нэг чухал хэсэг болдог зан үйлийн олон төрлөөс харж болохоор байна. Онгон шүтэх ёс ба хорио цээр нь нийгмийн хөгжлийн дараагийн үед шашны болон нийгмийн тогтолцоонд өөрийн ул мөрөө үлдээсэн тухай З.Фрейдийн үзэл баримтлалыг үндэс болгон өөрийн соёл, түүхийн ул мөрийг мөшгөн хөөж соёлын генеалоги асуудлыг судлах боломжтой гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Фрейд З. (2009). Онгон шүтлэг ба хорио цээр. Орч. Ж. Отгонбаяр. Улаанбаатар.
2. Монгол Улсын угсаатны зүй. (2012). Монгол улсын шинжлэх ухааны академи. I боть.
3. Түдэв Л. (2016). Цээрлэл зүй. Улаанбаатар.
4. Аръяасүрэн Ч., Нямбуу Х. (1992). Монгол ёс заншлын их тайлбар толь. БотыI. УБ.
5. Юнг К.Г. (2001). Психология безсознательного. Москва.
6. Фрэйзер Ж.Ж. (2011). Алтангишүү. Орч. Ж.Отгонбаяр. Улаанбаатар.
7. Чойжид дагинын тууж. (2009). Мунхагийн харанхуйг гэрэлтүүлэгч билгийн оршвой. УБ.
8. Пунсаг А. (2012). Монголын нууц товчоон дахь ёс заншил, зан үйлийн тайлбар толь. УБ.
9. Мөнхийн үсэг. (2009) Монгол ёс заншил, зан үйлийн товчоон.
10. Монгол Улсын угсаатны зүй. (2012). I боть. ШУА. Түүхийн хүрээлэн.

ABSTRACT

This article examines the concept of desire, fear, and belief in psychoanalytical theory. In Z. Freud theory, how to study the origin of quotes and quarantine and these cultural forms describe how Mongolian culture is connected. Freud explains the origin of the totemizm and taby based on ethnographic creations. In this way, Freud studied the social organization of the ancient period.